

МОНГОЛ, ШХАБ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭТИЙН ТӨЛӨВ

*В.Ариунчимэг**

***Abstract:** After the Cold War, when the Eurasian superpower the Soviet Union collapsed, the United States emerged as the only superpower in the world. Since then, an importance and influence of the Eurasian region became more and more weighty on the world stage. As China and Russia to develop a new level of communication and cooperation has intensified policy to strengthen its influence in Eurasia region. The expression of integration policy of the two Giants is the reason for the Shanghai Cooperation Organization /SCO/ was founded. The main mechanism of regional cooperation as the Shanghai Cooperation Organization in this region was expected to be expanded as political and economic impact in the future. Thus, Mongolia cooperation with SCO is very important issue in the field of international relations.*

***Key words:** Relations of the Russia and the China Security, Terrorism, Foreign Policy, Economic Relations, Giants policy forward in Eurasia, Energy Policy*

* * *

ШХАБ-ын өргөжин тэлэлт, нөлөө:

XXI зуун гарснаас хойш дэлхий дээр олон улсын харилцааны шинэ механизмууд бүрэлдэн тогтож, олон өөр чиглэл зорилгоор хөгжиж байгаагын нэг нь бүс нутгийн хамтын ажиллагаа юм. Өнөөдөр Евразийн бүс нутагт улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж, цар хүрээ, нөлөө, ач холбогдол нь улам өргөжиж, энэ бүс нутгийн олон улсын харилцаанд эзлэх жин нь нэмэгдэж байна. Евразийн гол бүс нутаг Төв Азид хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнууд зонхилдог, эдийн засаг, байгалийн баялаг, эрчим хүчний эх нөөц чадавхиараа өвөрмөц субъектийн хувьд дэлхийн болон бүс нутгийн их гүрнүүдийн анхаарлын төвд байдаг онцлогтой.

Их гүрнүүдийн ашиг сонирхол төвлөрсөн ийм бүс нутагт хамтын ажиллагааны байгууллагууд, холбоо эвслүүд геополитикийн агуулгаар олон улсын харилцааны чигийг тодорхойлоход нөлөөлөхүйц субъект болж өргөжин тэлж байна. Евразийн бүс нутгийн хамтын ажиллагааны гол механизм Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын улс төр, эдийн засгийн нөлөө улам өргөжих төлөвтэй боллоо. Олон улсын харилцааны өнөөгийн тогтворгүй, хувьсамтгай байдлын үр нөлөөгөөр энэ байгууллагын хөгжлийг улс төрийн талаас нь ОХУ, эдийн засгийн талаас нь БНХАУ удирдан залах төлөв улам бүр тодорч байна.

Түүхэн цаг үед Евразийн бүс нутагт их гүрэн байсан гэсэн үзэл санаа шингэсэн ОХУ-ын хувьд Төв Ази нь амин чухал бүс нутаг юм. Бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад эрчим хүчний нөөц рүү чиглэсэн их гүрнүүдийн ашиг сонирхлын тэнцвэртэй чухал үүрэгтэй. Төв Азид дэлхийн 2 дахь эдийн засаг Хятадын ашиг

* МУИС, ОУХНУС-ийн магистр

сонирхол ч Оросоос дутахааргүй түвшинд байна. Сүүлийн жилүүдэд Хятад нь Төв Азид их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, Төв Азийг дамнансан стратегийн чухал төслүүд хэрэгжүүлэхээр зорьж байна. Дэлхийн улс төр, эдийн засаг, хүчний тэнцвэрт нөлөө бүхий ОХУ, БНХАУ хэмээх хоёр их хөршийн дунд оршиж байгаа Монгол Улсын хувьд бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцид оролцохоос аргагүй нөхцөлд байна.⁷⁹

Онолын талаасаа Оросын Евразид их гүрний байр сууриа эргэн олж авах үзэл санаа хүчтэй байна. Еврази нь газарзүйн хувьд Ази, Европ хоёр тивийг холбосон дэлхийн эх газрын хамгийн том газар нутгийг хамардаг, геополитикийн хувьд том гүрнүүдийн ашиг сонирхлын бүс нутаг юм. “Еврази нь геополитикийн агуулгаараа дэлхийн хамгийн чухал бүс нутаг”⁸⁰ гэж АНУ-ын геостратегич Збигнев Бжезинский “Шатрын аварга хөлөг” хэмээх алдарт бүтээлдээ тодорхойлсон байдаг.

БНХАУ-ын хувьд ч Евразид нөлөөтэй байх сонирхолтой. 2013 онд Хятадын дарга Си Зиньпин “Шинэ торгоны зам” санаачилгыг зарлахад олон улс цочирдоогүй юм. “II мянганы өмнө Евразийн ард түмэн Ази, Европ, Африк тивийн иргэншлийг холбосон худалдаа, соёлын солилцооны хэд хэдэн замыг нээсэн. Үүнийг Хятадын дараагийн үеийн Торгоны зам хэмээн нэрлэсэн байдаг.”⁸¹ Хятадын өнөөгийн улс төр, эдийн засгийн хөгжил, потенциал Евразийн бүс нутагт нөлөөтэй байх боломжийг бүрдүүлж өгч байна. Хоёр том гүрний хамтын хүчээ нэгтгэх бодлогын нэг илрэл нь Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/ үүсэн байгуулагдсан учир шалтгаан юм. Өнөөдөр Евразийн бүс нутагт ШХАБ, ТУХН, Евразийн Эдийн засгийн холбоо зэрэг байгууллагууд өргөжин, хөгжиж улс төр, эдийн засаг, аюулгүй байдал гэх мэт олон салбарт үйл ажиллагаагаа эрчимжүүлэх төлөвтэй байна. Дэлхийд гүрэн улс, бүс нутагтаа их гүрэн, цаашид дэлхийн их гүрэн болох зорилготой ОХУ болон БНХАУ гэсэн удирдлага, төвтэй ШХАБ-ын үүрэг нөлөө, тэлэлт сүүлийн жилүүдэд эрс нэмэгдлээ. ШХАБ-ыг цаашид улс төр, геополитикийн түвшинд Орос, Хятадын дэг журмыг гаргаж ирэх нөлөө бүхий байгууллага гэж олон улсад харах боллоо.

2001 оны 6-р сарын 15-нд БНХАУ-ын Шанхай хотноо байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/ нь Зүүн Европ, Төв Ази, Зүүн Өмнөд Азийн улс орнуудаас бүрдсэн бүс нутгийн олон улсын байгууллага юм. ШХАБ нь БНХАУ, ОХУ, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Киргизстан Улс, Бүгд Найрамдах Тажикистан Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улс зэрэг 6 орны бүрэлдэхүүнтэйгээр Евразийн төвд төвлөрсөн, бүс нутгийн нөлөө бүхий бүтэц, механизм болон өргөжиж байна.⁸² Өнөөдрийн байдлаар ШХАБ-д ажиглагч гишүүн Монгол, Афганистан, Беларус, Иран, яриа хэлэлцээний түншээр Армени, Азербайжан, Камбож, Балба, Турк, Шри-Ланк, зочноор АСЕАН, ТУХН-ийн орнууд, Туркменистан улс багтаж байна. 2015 оны 7-р сард ОХУ-ын Уфа хотноо болсон

⁷⁹ The Eurasia Idea by Alexander Dugin, paper, 1, November, 2009.

⁸⁰ The Grand Chessboard by Zbigniew Brzezinski, 1997.

⁸¹ http://en.theorychina.org/xsqr_2477/201504/t20150407_321152.shtml

⁸² Удо Б.Баркманн, Төв Азийн геополитикийн орчны хувьсал ба Монгол улсын аюулгүй байдал, МУ-ын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ, 197-213

ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтаар Энэтхэг, Пакистан хоёр улсыг ШХАБ-д гишүүнээр элсүүлэхээр тохирч, одоо энэ хоёр улсыг албан ёсоор гишүүнчлэх үйл явц үндсэндээ шийдэгдэж дуусч байна.⁸³ Гишүүн орнуудынхаа дунд сайн хөршийн харилцаа, хоёр талын итгэлцлийг бэхжүүлэх, улс төр, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, технологи, соёл боловсрол, эрчим хүч, тээвэр, аялал жуулчлал, байгаль орчин хамгаалах зэрэг салбарт үр дүнтэй хамтын ажиллагааг дэмжих, бүс нутгийн энх тайван, аюулгүй, тогтвортой байдлыг сахин хамгаалахад хамтын хүчин чармайлт гаргах, терроризм, салан тусгаарлах үзэл болон хэт даврах үзлийн бүх хэлбэр, хар тамхины хууль бус наймаатай хамтран тэмцэх, шинэ, ардчилсан улс төр, эдийн засгийн шинэ дэг журам тогтоох нь ШХАБ-ын үндсэн зорилго юм.

Энэхүү бүс нутгийн байгууллагад ОХУ, БНХАУ гэсэн цөмийн зэвсэгтэй 2 улс, цөмийн зэвсэгтэй нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй Энэтхэг, Пакистан гэсэн 2 улс хамаарч байна. Ажиглагчийн статустай Иран цөмийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаад 2015 оны 7-р сард НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүн Герман гэсэн бүлэгтэй цөмийн хөтөлбөрөө зогсоох тухай гэрээ байгуулж, цөмийн хөтөлбөр нь зогсоод байна. ШХАБ нь дэлхийн ашиг сонирхлын төвд байдаг, олон улсын улс төр, эдийн засгийн бүтцэд өөрийн гэсэн байр суурьтай, байгалийн баялаг, газарзүйн байрлал нийгмийн байгууламж, соёл иргэншлийн хувьд олон улсын харилцааны хамгийн өвөрмөц субъект гэгддэг Төв Азид төвтэйгээр өргөжиж байна. Төв Ази нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд буюу нөлөөний хүрээнд багтаж байсан нутаг дэвсгэр, Исламын шашинтай ард түмэн зонхилсон, эдийн засгийн хөгжлийн хувьд дэлхийн хөгжлийн зах хязгаар, үндэстэн ястан хоорондын мөргөлдөөн хялбар тархах эрсдэлтэй, улс төрийн хувьд тогтворгүй байдал зонхилдог, байгалийн баялгийн нөөцөөр арвин бүс нутаг юм. Иймд Төв Ази нь том гүрнүүдийн ашиг сонирхлын төвд байдаг.”⁸⁴ Энэ тодорхойлолтоос харахад Төв Ази нь XXI зуунд дэлхийн эдийн засагт эрчим хүчний чухал уурхайн нэг болох төлөв харагдаж байна. Гэхдээ энэ бүсэд эдийн засгийн хөгжлөөр сул, хүн амын боловсролын түвшин харьцангуй боломжийн, дэд бүтцийн хөгжил муу орнууд оршиж байна. Харин газарзүйн хувьд бүс нутаг нь дэлхийн чухал бүс нутгууд руу гарах гарц дээр оршдог нь Төв Азийн давуу тал юм. Байгалийн баялаг ялангуяа эрчим хүчний эх нөөцөөрөө дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын анхаарлыг татаж байгаа Төв Ази нь XXI зуунд эрчим хүчний эх үүсвэр гэдэг утгаараа Персийн булангийн гол өрсөлдөгч болж тодрох төлөвтэй гэж судлаачид үздэг.⁸⁵ “Төв Азийн орнуудад дотоодын асуудал нэг зэрэг тулгарч байгаа нь ОХУ, БНХАУ, АНУ, Иран, Пакистан зэрэг орнуудын улс төрийн бодлогоос шууд хамааралтай”⁸⁶ гэсэн нь нэг талаар бодит үнэн юм. Мөн судлаачид терроризм, салан тусгаарлах үзэл бол Төв Азид хэзээ хэзээгүй тэсэрч болзошгүй “дарьтай торх” гэж хардаг. Төв Азийн орнууд Исламын шашинт хүн ам ихтэй, терроризм үүрлэсэн газар нутагтай хиллэдэг учраас энэ бүс нутагт исламын шашны хэт тулгуур үзлийг түгээн дэлгэрүүлэхэд нийгмийн дархлаа сул юм. Төв

⁸³ https://en.wikipedia.org/wiki/Shanghai_Cooperation_Organisation

⁸⁴ МУ-н ШУА, ОУС хүрээлэн, Төв Азийн Геополитик ба Монгол улс, хуудас 6, 2005.

⁸⁵ МУ-н ШУА, ОУ судлалын хүрээлэн, Төв Азийн геополитик ба Монгол улс, хуудас 9, 2005 он.

⁸⁶ К.Дэмбэрэл, Төв Азийн Геополитик ба Монгол улс, хуудас 9, 2005.

Ази нь хэдийгээр дэлхийн худалдааны зам хэдий ч гадаад далайд шууд гарцгүй байдал нь түүнийг хүчгүйдүүлж байдаг. Мөн бүс нутгийн орнуудын эдийн засгийн чадавхи нь харилцан өөрсдийгөө нөхөх бус харилцан өрсөлддөг чанартай байгаа нь их гүрнүүдийн нөлөө бэхжих суурь болж байна.

ОХУ-ын Евразид баримталж байгаа бодлого

Хүйтэн дайны дараах үе дуусаж, Өрнөд, Орос стратегийн шинэ зөрчилд шилжсэн. ОХУ өрнөд болон АНУ-ын дэлхийд тэргүүлэх бодлогыг эсэргүүцэх болсон нь дэлхийн тавцанд тэргүүлэгч болох сонирхлыг нь нотолж байгаа юм. Оросын судлаачид ч АНУ дэлхийн их гүрэн байх оргил үеэ өнгөрөөсөн, Пакс Америка гарцаагүй уналтын үе рүүгээ шилжлээ гэж дүгнэх болжээ. Энэ нь ОХУ-ыг Евразийн эх газарт дэлхийн их гүрэн болох, ашиг сонирхлоо хадгалах, гол бүс нутгуудад нөлөөгөө тэлэх, газар нутгаа ялангуяа Европд тэлэх боломжийг олгож байгаа юм. ОХУ-ын ШХАБ дахь ашиг сонирхол нь Төв Ази, Хятад-Оросын харилцаа, Өрнөдтэй ялангуяа АНУ-тай харилцах харилцаа, дэлхийн улс төрд нөлөөтэй байх гэсэн 4 өөр түвшинд харилцах цогц институц бий болгоход чиглэсэн. Төв Ази нь Оросын ашиг сонирхлын нөлөөний бүс төдийгүй тэнд Орос үндэсний 5 сая хүн аж төрж байна. Тэдний сэтгэлгээг Орост элэгтэй байлгах нь Оросын хуучин ЗХУ, цаашлаад Оросын эзэнт гүрний талбар дээр нөлөөгөө бэхжүүлэх далд сонирхлын нэг өчүүхэн хэсэг нь. ОХУ Төв Азийн орнууд буюу ШХАБ-ын гишүүн орнуудтай нягт, ойр харилцаатай төдийгүй ТУХН-ийн хүрээнд ч нөлөөтэй тоглогч нь. Мөн нөгөө талаар Москва Төв Азид байр сууриа бэхжүүлэх, АНУ-ын нөлөөг хязгаарлах зорилго агуулж, энэ бүсийн улс орнуудтай улс төр, эдийн засгийн хувьд хэт ойртох болсон БНХАУ-ын Төв Ази дахь ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх, хүчний тэнцвэрийг барих бодлогыг ШХАБ-ын хүрээнд баримталж байна. Харин Хятад улс Төв Азид эдийн засгийн хүчтэй бодлого баримталж, эрчим хүчний эрэлтээ хангах, үүний тулд асар их хэмжээний хөрөнгө оруулалт хийх үйл явц Өрнөдийн оролцоогүйгээр урагшилсаар байвал ОХУ ШХАБ-ын хүрээнд л энэ үйл явцыг тогтоон барих боломж бий. БНХАУ нь эдийн засгийн үзүүлэлтээрээ дэлхийд /11.212 триллион америк доллар/ АНУ-ын дараа хоёрт бичигддэг. 2015 онд Хятадын эдийн засгийн өсөлт 6.9%-тай байсан нь 2009 оноос хойш хамгийн сул өсөлт боловч дэлхий дээр хамгийн өндөр хувьтай өсөлт юм. Хятадын эдийн засгийн хурдтай өсөлт буурснаар Коммунист удирдагчдад нь дэлхийн номер 2 эдийн засгаа хамгаалж, тогтвортой өсөлтийн замд оруулах чадамж бий эсэхэд олон улс эргэлзэж байна. Дэлхийн банк Хятадын ДНБ-ий өсөлт 2015 онд 7.1%, 2006 онд 7.0%, 2017 онд 6.9% байна гэсэн өөдрөг таамаг дэвшүүлж байна.⁸⁷ Гэхдээ эдийн засагчид Хятадын эдийн засгийн өсөлт суларсан нь муу үзүүлэлт биш, харин ч дэлхийн дундаж руу орж ирж тогтворжиж байна гэж дүгнэх болсон. Хятадын эрх баригчид ч эдийн засгийнхаа үсрэнгүй өсөлтийг сэргээх бус одоогийн энэ 7%-ийн өсөлтөнд тогтвортой барих бодлого хэрэгжүүлж байна. Хятадтай хилийн маргаангүй, Төв Ази дахь Хятадын тэлэлтийг илт илэрхий эсэргүүцэхгүй байх нь ОХУ-ын хувьд цэрэг, зэвсгийн хүчин чадлаа тэлэх ялангуяа

⁸⁷ World Bank Forecast table, Global Outlook in Summary

Хойд Кавказад нөлөөтэй байх боломжийг өгөх юм. Гэхдээ Хятадын Төв Ази дахь тэлэлтээс илүүтэйгээр ОХУ-ын ШХАБ-ын үүсгэн байгуулалцах, цаашид үүрэг нөлөөг нь нэмэгдүүлэх сэдлийг АНУ, НАТО хоёр өгч байгаа гэж үзэж болно.⁸⁸ Сүүлийн жилүүдэд дотоодын болон бүс нутгийн дайн, зөрчилд давамгайл байдлаа харуулах зорилгоор батлан хамгаалах салбарын зардал, төсөвөө үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж байна. ОХУ нь 2015 оны байдлаар батлах хамгаалахын зардлаараа (53.2 тэрбум ам.доллар) дэлхийд АНУ(571), БНХАУ (129.4), Их Британи (66.5)-ын дараа 4-рт жагсаж байна. Батлан хамгаалахын төсөв 2014 оны байдлаар ДНБ-ийх нь 4.5%-тай тэнцсэн байна. 2011-2014 онд ДНБ-ийх нь 3.7-4.5 %-ийн хооронд хэлбэлзжээ.⁸⁹ Евразийн бүс нутагт Америкийн нөлөөг хязгаарлахын тулд БНХАУ сүүлийн жилүүдэд Евразийн бүс нутагт геополитикийн холбоотон, эдийн засгийн шинэ боломж бололцоог эрэлхийлэх болсон юм. Үүний нэг илрэл нь 2013 оны 9-р сард зарласан Шинэ Торгоны Зам эдийн засгийн бүс байгуулах санаачлага.⁹⁰ Энэ нь эртний торгоны замын дагуу орших Евразийн улс орнуудын дунд улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилготой Хятадын холыг харсан санаачлага юм. Өрнөдийн судлаачид БНХАУ-ын Шинэ Торгоны зам санаачлагыг Номхон далайн зуунд ноёрхлоо тогтоохын төлөөх Америк улстай өрсөлдөх “Хятадын Евразийн зууны эхлэл” гэж дүгнэх болсон юм.

Энэ улсын XXI зуунд дэлхийн их гүрэн болох сонирхол, зөөлөн хүчний бодлогод тулгуурлан урагшилж байгааг нэг тод илрэл нь ШХАБ-д баримтлаж байгаа бодлого, үйл ажиллагаа юм. Үүний зэрэгцээ зөөлөн бодлогынх нь хатуу талыг харуулах болсон терроризм, салан тусгаарлах байдал Хятадыг ШХАБ-д давуу нөлөөтэй байх, Төв Азид хөрөнгө хүчээ чиглүүлэхэд нь нэг талаар нөлөөлж байна. Хятадын хувьд Төв Азиас цухалцах болсон терроризм, салан тусгаарлах үйл ажиллагаа үндэсний ашиг сонирхолд нь заналхийлэгч нэг хүчин зүйл гэж үзэх болсон юм. Хятадын шинэ удирдлагын Төв Азид баримтлах гадаад бодлого, Энэтхэг, Пакистан, Турк зэрэг орнууд ОХУ, БНХАУ, болон АНУ, ЕХ-ны хооронд гүүр болж бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцуулж чадах эсэхээс ШХАБ-ын тэлэлт, түүний ирээдүй ихээхэн хамаарч магадгүй юм.

ШХАБ-ын хүрэн дэх цэргийн аюулгүй байдал, ШХАБ ба НАТО

ОХУ-ын цэрэг армийн зардал, хүчин чадал нэмэгдэж байна. ОХУ 2015 онд батлан хамгаалах зардалдаа 3.3 триллион рубль зарцуулахаар төсөвлөсөн юм. ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин 2025 он хүртэл батлан хамгаалах салбарын тоног төхөөрөмж авахад 20 триллион рубль буюу 700 тэрбум америк доллар зарцуулахаар төлөвлөв. Өнөөдрийн байдлаар ОХУ-ын батлан хамгаалахын төсөв дэлхийд АНУ, БНХАУ-ын дараа гуравт эрэмбэлэгддэг. Украины хямрал ОХУ-ын зэвсгийн худалдааг нэмэгдүүлэх бас нэг хүчин зүйл болох үндэслэлтэйг шинжээчид онцолдог юм. Украины хямрал дахь Оросын оролцооны хариуд АНУ болон

⁸⁸ Expanding Eurasia: Russia's European Ambitions, by Janusz Bugajski , page 1, August, 2008

⁸⁹ The World Bank data <http://data.worldbank.org/indicator/MS.MIL.XPND.GD.ZS>

⁹⁰ Chronology of China's Belt and Road Initiative http://news.xinhuanet.com/english/2015-03/28/c_134105435.htm

Европын холбооны тавьсан эдийн засгийн хориг Оросын зэвсгийн худалдаанд төдийлөн нөлөө үзүүлэхгүй. Учир нь Орост дотоодын зах зээлээс гадна Энэтхэг, Хятад гэсэн хоёр том зэвсгийн худалдан авагч түнш байна. Энэ бүс нутагт хийгддэг эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн чухал хэсэг нь зэвсгийн худалдаа, энд ОХУ хамгийн гол нийлүүлэгч нь. Мөн эрчим хүчний салбарт ОХУ, Казахстан, Узбекистан, Иран хамгийн том экспортлогч орнууд юм. Харин БНХАУ, Энэтхэг хоёр эрчим хүч, зэвсгийн аль алиных нь гол импортлогчид. БНХАУ-ын цэргийн төсөв 2011-ээс 2014 оны хооронд ДНБ-ийнх нь 2.0-2.1%-тай тэнцжээ. БНХАУ 2013 онд цэрэг батлан хамгаалах салбартаа 176 тэрбум америк доллар зарцуулсан бол 2015 онд 190 тэрбум америк доллар зарцуулсан байна. Хятад улс 2020 он хүртэл цэрэг батлан хамгаалахын төсвөө жил бүр 7%-иар нэмэгдүүлж, 260 тэрбум америк долларт хүргэнэ гэсэн урьдчилсан таамаг гарсан байна.⁹¹ Ер нь 2020 он гэхэд дэлхийн цэрэг батлан хамгаалах салбарын хүндийн жин Баруун Европ, Хойд Америкийн хөгжингүй орнуудаас Ази тивийн үсрэнгүй эдийн засагтай орнууд руу шилжих төлөвтэй байна.⁹² БНХАУ болон ОХУ –ын зэвсэгт хүчний хүчин чадал өнөөдөр дэлхийд АНУ-ын дараа хоёр, гуравдугаарт жагсаж байна. Эндээс БНХАУ болон ОХУ хоёр ШХАБ-д гол тоглогч гэдэг нь харагдаж байна. Хүйтэн дайны дараах олон улсын харилцаанд гарсан өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр НАТО-той сөргөлдөж байсан Варшавын гэрээний байгууллага 1990-ээд оны эхэн үед татан буугдсанаар НАТО геополитикийн талбарт өрсөлдөгчгүй, дангаар тоглолт хийх боломжтой болсон юм. Хэдийгээр энэ үед хуучин ЗХУ задарч, Евразийн цээжинд шинэ тусгаар улсууд бүрэлдэн тогтох үйл явц ид өрнөж байсан ч геополитикийн энэ сул орон зайд Хойд Атлантын Гэрээний байгууллага (НАТО)-гийн дорно зүгт тэлэх бодлогыг хязгаарлах далд зорилготой ОХУ, БНХАУ-аар толгойлуулсан шинэ механизм ШХАБ бүрэлдэн тогтсон.

ШХАБ НАТО-г сөрсөн цэргийн эвсэл үү, үгүй юу, эсвэл ирээдүйд цэргийн эвсэл болох уу? Үүний гаргалгааг гаргахын өмнө цэргийн эвсэл гэж өөрөө юу вэ? Цэргийн эвсэл гэдэг нь нэг командан дор нэгдэж, цэргийн ажиллагаанд оролцож байгаа улс орнуудын нэгдлийг хэлдэг.⁹³ Хойд Атлантын Гэрээний Байгууллага НАТО нь өнөөгийн дэлхий ертөнц дэх цэргийн цорын ганц сонгодог эвсэл юм. НАТО 1949 онд Бельгийн нийслэл Брюссельд төвтэйгээр байгуулагдсан, 28 гишүүн оронтой цэргийн эвсэл. Судлаачид НАТО-г Хүйтэн дайнаас хойш дэлхийд АНУ-ын тэргүүлэх нэг тэнхлэгийн бодлогыг хэрэгжүүлэх зорилго бүхий цэргийн эвсэл болсон гэж үздэг. НАТО-гийн дүрэмд энэ байгууллагын гол зорилго нь гишүүн орнуудын эрх чөлөө, аюулгүй байдлыг улс төр, цэрэг зэвсгийн хүчээр хангах, Европт шударга бөгөөд бат бөх, энх тайван тогтоож ардчилал хүний эрх, эрх чөлөөг эрхзүйт төрийн үндсэн дээр бэхжүүлэх явдал гэж заасан байдаг. Тухайлбал НАТО-гийн дүрмийн 5-р заалтаар НАТО-гийн гишүүн аль нэг улсад халдсан нөхцөлд үүнийг НАТО-гийн бүх улс орны аюулгүй байдалд халдсан гэж үздэг. НАТО-гийн

⁹¹ М.Батчимэг, БНХАУ-ын стратегийн гадаад орчин ба гадаад бодлогын чиг хандлага, Стратеги судлал сэтгүүл 2003

⁹² China is investing in central Asia, http://www.asiaecon.org/special_articles/read_sp/12835

⁹³ Is the SCO Emerging as Eastern Counterweight to NATO http://www.realcleardefense.com/articles/2015/08/31/is_the_sco_emerging_as_eastern_counterweight_to_nato_108426.html

дүрмийн 5-р заалтыг түүхэнд анх удаа АНУ-д 2001 оны 9-р сарын 11-нд террорист халдлага гарсны дараа хэрэгжүүлсэн байдаг. Мөн цэргийн бие бүрэлдэхүүнээ эвслийнхээ хамтын аюулгүй байдлыг сахин хамгаалахад идэвхтэй, байнгын бэлэн байдалд байлгадаг юм.

Харин ШХАБ өөрөө ялангуяа гол 2 гишүүн Орос, Хятад цэргийн эвсэл гэж цоллох Өрнөдийн хандлагад яаж хандаж байна вэ гэдэг судлаачдын анхаарал татдаг сэдэв. ШХАБ-ыг АНУ-ын эсрэг мөн Өрнөдийн цэргийн эвсэл НАТО-г сөрсөн байгууллага уу, биш үү гэдэг дээр олон янзын байр суурь байдаг. ОХУ-ын зарим эрдэмтэд ШХАБ-ыг Өрнөдийн цэргийн эвсэл НАТО-той ижил түвшинд хүргэх зорилт одоохондоо үр дүнд хүрэхгүй. Өрнөдтэй олон салбарт хамтын ажиллагаатай байх сонирхолтой ШХАБ-ын гишүүн зарим улс орнуудын суурь ашиг сонирхол хөндөгдөх учраас өөрсдийн эдийн засаг, зах зээлийнхээ чадамжийг сайжруулсан нөхцөлд л цэргийн эвсэл болох сонирхлоо идэвхжүүлж магадгүй юм гэсэн хувилбар гаргаж ирсэн байдаг. АНУ-ын Аюулгүй байдлын бодлогын судалгааны төвийн Зүүн Ази судлаач Фредерик Стейкелбек “ШХАБ нь дэлхий нийтийг тогтворгүй байдалд хүргэж, дайн ч өдөөж мэдэхээр байсан Хүйтэн дайны сүүдрээс гарч байгаа хүчирхэг гүрнүүдийн том эвсэл юм. Геополитикийн талаасаа ШХАБ-д Оросын эрчим хүч, цэрэг, технологийн туршлага, Хятад, Энэтхэгийн эдийн засаг, хүний нөөц, Ираны эрчим хүчний асар их нөөц, өсөн нэмэгдэж буй цэрэг армийн хүчин чадлыг нэгтгэж, дэлхий дээрх хамгийн хүчирхэг эвсэл болох боломж бий. Энэ хосгүй нэгдэл ШХАБ-ыг АНУ-ын хувьд аюултай дайсан нь болгож байгаа юм”⁹⁴ гэж 2005 оны нийтлэлдээ онцолсон байна. Мөн үүний адил Херитэйж сангийн ахлах шинжээч Петер Брүүкс “ОХУ армийн хүчин чадал, том эдийн засаг, цөмийн зэвсэг, газрын тос, байгалийн хийн асар их нөөц баялагтаа тулгуурлаж, шинээр “Азийн Варшавын гэрээ-2”-ыг байгуулах сонирхолтой байна”⁹⁵ гэсэн өнцөгийг гаргаж ирсэн байна.

Оросын хувьд ШХАБ-ыг Барууны эсрэг ашиглах боломжтой, хүчтэй зэвсэг байдлаар харуулах цаг хугацааны зохицол Украины хямралын үеэр таарав. Украины хямралыг тойрсон үйл явдлуудтай уялдаа холбоотой одоогийн энэ нөхцөлд Орос, Хятадын цэргийн хамтарсан ямар ч сургуулилт Баруунд “дохио” болж харагдана гэж Оросын гадаад харилцааны шинжээч Фёдор Луканов *Свободная Пресса* цахим хуудсанд өгсөн ярилцлагадаа онцолсон байна. Түүний гаргалгаагаар Хятад, Оросын цэрэг армийн хамтын ажиллагаанд бодитой хязгаарлах зүйл бий. Өөрөөр хэлбэл БНХАУ-д цэргийн эвсэлд орох ашиг сонирхол байхгүй, энэ улс аюулгүй байдлын ашиг сонирхлоо заавал ОХУ-ынхтай давхцуулах шаардлагагүй. Гэхдээ АНУ, НАТО Афганистанаас цэргээ гаргасны дараа эндээс аюул занал учрах вий гэсэн болгоомжлол Бээжин, Москвагийн аль алинд байгаа учир Төв Ази, ШХАБ-ын орчинд аюулгүй байдлаа хамтран хангах сонирхол байж болох юм.

ШХАБ-ыг удирдан залж, эдийн засгийн хүчин чадлынхаа багагүй хувийг зарцуулж байгаа ОХУ, БНХАУ гэсэн хоёр бүс нутгийн их гүрний эдийн засаг, улс

⁹⁴ Is the Shanghai Cooperation Organization a Military Confederacy? Frederick Stakelbeck, Jr., 9/26/2005.

⁹⁵ Peter Brookes, “Club For Dictators: An ugly agenda for Asia”, The Heritage Foundation, June 12, 2006

төр, батлан хамгаалахын хүчин чадал ч ШХАБ-ыг НАТО-гийн эсрэг цэргийн эвсэл болон хөгжүүлэх үндэслэлтэйг харуулж байна. Мөн ОХУ, БНХАУ хоёр хоёулаа цөмийн зэвсэгтэй, цэрэг, батлан хамгаалахын хүч чадал, энэ салбарт зарцуулж байгаа хөрөнгө мөнгө сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байна. Үүний зэрэгцээ олон улсын тавцанд ШХАБ-ыг НАТО-г сөрөх цэргийн эвсэл болгох цаг хугацааны эрэлт гарч ирж байгаа юм. 2001 оны террорист халдлага, 2014 оноос эхэлсэн Украины хямрал, 2011 оноос эхтэй Сирийн иргэний дайн зэрэг геополитикийн хүчин зүйлүүд Орос, Хятадыг хүчээ нэгтгэх, Өрнөдийн дэлхийд ноёлох бодлогын эсрэг байнгын ажиллагаатай байх цэргийн эвсэл бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж болохоор байна. Яг өнөөдрийн түвшинд ШХАБ-ыг НАТО-г сөрсөн цэргийн эвсэл мөн үү гэж харвал, энэ байгууллагын үйл ажиллагаа НАТО шиг төгс хэлбэрээр хөгжөөгүй байна.

ШХАБ-ын гишүүнчлэлийг тэлэх нь Евразийн бүс нутаг дотроо эдийн засаг, аюулгүй байдлын түвшинд хамтын ажиллагааг өргөжүүлэх индэр болох юм. Шинээр элсүүлэх гэж байгаа Энэтхэг, Пакистаны хувьд хоёулаа терроризм, салан тусгаарлах, хэт даврах үзэлтэй тулгарч байгаа. Иймд Энэтхэг, Пакистан ШХАБ-д гишүүнчилснээр дотоодын аюулгүй байдлын орчноо сайжруулахад бодит алхам болж магадгүй юм. Орос, Хятадын аль алинд ШХАБ-д аль болох олон орныг нэгтгэж, энэ механизмыг олон улсын том асуудлуудыг шийдэх индэр болгох, эдийн засгийн потенциалыг нь нэмэгдүүлж, үүгээрээ гишүүнчлэлээ өргөжүүлэх хөшүүрэг болгох сонирхолтой байна.

Монгол Улсын ШХАБ-д баримтлах бодлого, байр суурь

Монгол Улс нь Зүүн Хойд Ази, Төв Азийн бүс нутгийн аль алинд нь хамрагдах газарзүйн онцлог байрлалтай. Эдгээр бүс нутагт өрнөж буй улс төр, эдийн засгийн олон талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцохыг гадаад бодлогынхоо нэг чиглэл гэж үздэг. Иймд Монгол Улс ШХАБ-ыг Төв Азийн бүс нутгийн олон талт хамтын ажиллагаанд оролцох чухал гарц гэсэн өнцгөөс харж, 2004 онд тус байгууллагын анхны ажиглагч гишүүн болсон юм. Үүнээс хойш 12 дахь жилдээ ажиглагчийн байр сууриар идэвхтэй хамтран ажиллаж байна. Монгол Улс нь эдийн засгийн хамтын ажиллагаанд илүү ач холбогдол өгч байгаа ШХАБ-ын хүрээний янз бүрийн түвшний арга хэмжээнд оролцох сонирхолтой гэдгээ ч илэрхийлж ирсэн юм.

Монгол Улс нь ШХАБ-ын гишүүн улс орнуудын хооронд худалдаа, эдийн засгийн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарч, хамрагдах боломжийг судалж ирсний зэрэгцээ энэхүү хөтөлбөртэй төстэй хөтөлбөрүүдийг үндсэн гишүүн, ажиглагч, яриа хэлэлцээний түнш орнуудын оролцоотойгоор боловсруулан гаргах саналыг дэвшүүлсэн байдаг. Монгол Улсын Засгийн газар ШХАБ-ын үйл ажиллагаанд Монгол улс идэвхтэй оролцохыг эрмэлзэж ирсэн бөгөөд худалдаа эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл болгож байгаад Монголын засгийн газар өндөр ач холбогдлол өгч ирснийг онцолж байсан юм.⁹⁶ Өнөөдрийн байдлаар

⁹⁶ <http://sonin.mn/news/politics-economy/22296>

ШХАБ-ын гишүүн орнуудын эдийн засаг ДНБ-ий 20 орчим хувийг эзэлж, эдийн засгийн интеграцийн чадавхи нь нэмэгдэж байна. Хэдийгээр дэлхийн хоёр том гүрнийг багтаасан эдийн засаг, улс төр, аюулгүй байдлын томоохон механизм бий болох бололцоо байгаа ч ШХАБ-ын дотоодын саналын зөрүүтэй зарим асуудал арилахгүй байгаа нь энэ байгууллагын үйл ажиллагаа жигдрэхэд саад учруулж байна. Ийм нөхцөлд Монгол Улс ШХАБ-д элсэх үү, үгүй юу гэдэг хоёр сонголтын өмнө тулж ирээд байгаа юм. Гэхдээ Монгол Улс ШХАБ-ын талаар баримталж байгаа маш тодорхой байр суурьтай. ОХУ, БНХАУ-ын зүгээс энэ байгууллагад Монгол Улсыг оролцуулах сонирхолтой байгаагаа тогтмол илэрхийлж байдаг боловч манай улс ШХАБ-ын хөгжил, ирээдүйн төлөвийг анхааралтай ажиглаж, харзнаж байна. Энэ нь юуны өмнө ШХАБ бүрэн төлөвшөөгүй, үйл ажиллагаа нь жигдрэх шатандаа яваа тул түүний хөгжлийн хандлагыг тодорхойлоход тодорхой цаг хугацаа хэрэгтэй байгаатай холбоотой. Нөлөө талаар тус байгууллагыг голчлон цэрэг, улс төрийн болон аюулгүй байдлын өнцөгөөс харах явдал бусад орны хувьд нэлээд түгээмэл байгаатай энэ нь бас уялдаатай болно.⁹⁷

Яг өнөөдрийн түвшинд ШХАБ-ыг өргөжүүлэх, шинэ гишүүн элсүүлэх тэр дундаа Монгол Улсыг элсүүлэх сонирхол хоёр хөршид их байна. Хоёр хөршийн Монгол Улсыг ШХАБ-д орохыг шахах шалтгаан цаагуураа АНУ болон Өрнөдтэй сөргөлдөж байгаатай нь холбоотой гэж үзэх үндэстэй. “2014 оны 7-р сард Хятадын Гадаад хэргийн сайд Ван И Монгол Улсын Ерөнхий сайдаас ШХАБ-д бүрэн гишүүнчлэх талаар нааштай мэдээлэл авсан, тиймээс Монгол Улс ШХАБ-ын 7 дахь гишүүн болж магадгүй, энэ бол бидний хувьд сайны дохио”⁹⁸ гэсэн мэдэгдэл хийж байв. Иймэрхүү шахалтад үндэслээд ШХАБ-ын үйл ажиллагааны чиглэл, хандлага өргөжих төлөвтэй байгааг харгалзан, энэ байгууллагын талаар баримтлах бодлого, байр суурь, хамтран ажиллах чиглэлээ гүнзгийрүүлэн боловсруулах шаардлага гарч байгааг Монгол Улсын Засгийн газар ойлгож байгаа нь олон зүйл дээр ажиглагддаг. Тухайлбал 2014 онд ШХАБ-ын төрийн тэргүүн нарын 14 дэх удаагийн дээд хэмжээний уулзалтын өмнөх Монгол-ОХУ-БНХАУ-ын 3 талт уулзалтын үеэр Орос, Хятадын төрийн тэргүүн нар Монгол Улсыг ШХАБ-д жинхэнэ гишүүнээр элсэхийг дэмжихээ илэрхийлсэн юм. Харин Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж энэ байр сууринд “Монгол Улсад ажиглагчийн статус хангалттай” гэх утгатай хариулт өгсөн байдаг.⁹⁹ Мөн үүний өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “бид ШХАБ-ын хүрээнд эдийн засаг, дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдэд оролцох сонирхолтой байдаг, энэ байгууллагад бидний оролцооны түвшинг нэмэгдүүлбэ гэсэн ШХАБ-ын саналыг хүндэтгэж авч үздэг” гэж Оросын хэвлэлийнхний асуултад хариулсан нь Монгол Улс одоогоор ШХАБ-д ямар байр сууриар ханддаг, цаашид яаж оролцохоо ерөнхийд нь илэрхийлсэн алхам юм.

ШХАБ-ын өнөөгийн хөгжлийн байдлаас харвал цаашид улс төр, аюулгүй байдлаас гадна эдийн засгийн хамтын ажиллагааг тэргүүлэх чиглэлийн нэг болгох төлөв харагдаж байна. Энэ байгууллагын хүрээнд яригдаж эхэлж байгаа чөлөөт

⁹⁷ Д.Мягмар, Аюулгүй байдлын судалгааны зарим асуудал, хуудас 34, 2014 он.

⁹⁸ Will Mongolia Be The Next SCO Member? <http://www.eurasianet.org/node/69001>

⁹⁹ <http://www.infomongolia.com/ct/ci/8351>

худалдааны бүс, ачаа тээврийн бодлогын зохицуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, байгалийн гамшигтай хамтран тэмцэх, олон улсын терроризм, хил дамнасан гэмт хэрэг, хар тамхины наймааны эсрэг тэмцэх зэрэг асуудал нь манай улсын ашиг сонирхолтой зайлшгүй холбогдож байгаа юм.¹⁰⁰ Монгол Улсын хувьд ШХАБ-д бүрэн гишүүнчилснээр Орос, Хятад гэсэн хоёр их хөршийн нөлөөнд хэт автах, ирээдүйд ШХАБ цэргийн эвсэл болж өргөжих эрсдэлтэйг тооцоолж, гишүүнчлэлийн асуудал дээр нухацтай хандах байр сууриа олон жил хадгалж ирсэн. ШХАБ-д гишүүнчлэх нь Монголын гадаад бодлогын бие даасан байдлыг хумих эрсдэлтэй, жишээлбэл Монгол Улсын Хятад, Оросоос гадна түнштэй байх стратеги буюу “Туравдагч хөрш”-ийн бодлогод сөргөөр нөлөөлөх талтай. Мөн ШХАБ-д элссэнээр Монгол Улсын дотоодын ардчиллыг бэхжүүлэх хүчин чармайлт, Европын Холбоо болон АНУ-тай харилцах олон улсын дүр төрхийн аль алиныг дордуулж болзошгүй юм гэж Монгол Улсын улс төрийн шинжээч Ж.Мэндээгийн 2012 онд гаргасан “Монгол ба ШХАБ” өгүүлэлд бичжээ. Энэ нь нэг талаар үнэний үндэстэй, Монгол Улсын төр засаг ийм нөхцөлд урьдчилан сэргийлэх дипломат ажиллагааны арга хэрэгслийг ашиглах нь зүйтэй гэсэн санаа юм.

2012 онд Ази Номхон далайн стратеги, аюулгүй байдал судлаач Ричард Вейцийн нийтлэлд: “ОХУ, БНХАУ хоёр нь Монгол Улс ойрын үед ШХАБ-д элсэхгүй нь гэдгийг дуртай дургүй хүлээн зөвшөөрөх хандлагатай байна. Саяхан НАТО Монгол Улстай харилцаагаа өргөжүүлснийг Хятадын засгийн газар тааламжгүй хүлээж авлаа. Ер нь Хятад улс Монголын “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд Бээжин, Москвагийн нөлөөг тэнцвэржүүлэх үүднээс НАТО-той харилцаагаа ахиулаа гэж буруутгаж байна. Монгол Улс НАТО-гийн тэргүүлсэн Косово, Афганистан дахь цэргийн ажиллагаанд цэргээ илгээж, саяхны Чикагогийн дээд хэмжээний уулзалтад оролцоод зогсохгүй НАТО-гоос Бие даасан түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөрийг хүлээж авсан анхны орон боллоо”¹⁰¹ гэсэн нь Монголыг хоёр хөршөөсөө хэт хараат болохоос сэрэмжилж байна, үүнд нь хоёр хөрш нь ялангуяа өмнөд хөрш нь эмзэглэнгүй хандаж байгааг сануулсан гэж харж болох юм.

Монгол Улсын хувьд ШХАБ хоёр талаар нөлөө үзүүлэх боломжтой. Монгол ШХАБ-д элссэн нөхцөлд эдийн засгийн тусламж дэмжлэг хүртэх боломж бий. Ялангуяа одоогийн газрын тосны хараат байдлаас ангижрах, хойд, өмнөд хоёр хөршийн эрчим хүч, тээврийн салбарын хамтын ажиллагаанаас ашиг хүртэх зам харьцангуй нээлттэй болох юм. Нөгөө талаар ШХАБ-ын гишүүн болсноор АНУ тэргүүтэй Өрнөдийн орнуудын эсрэг чиглэсэн эвсэлд нэгдсэн гэдэг утгаар аюулгүй байдлын орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Хоёр том гүрний хамтын эвсэлд орсноор энэ хоёр улсаас хараат болох, тэдний тоглоомын дүрмээр явах нөхцөл бүрдэж магадгүй юм. Хэрвээ ШХАБ-д элссэний дараа хоёр том хөршийн ШХАБ-д баримталж байгаа улс төр, эдийн засгийн бодлого чиглэл өөрчлөгдөж, цэргийн эвсэл болох нөхцөлд Монгол Улсын түүхэн уламжлалт эвсэлд үл нэгдэх бодлого

¹⁰⁰ Д.Мягмар, Аюулгүй байдлын судалгааны зарим асуудал, хуудас 35, 2014 он

¹⁰¹ China-Russia's Anti-NATO? By Richard Weitz, July 04, 2012 <http://thediبلوماس.com/>

алдагдаж болзошгүйд хүрнэ. Ямар нэг цэргийн эвсэл байгууллагад элсэх нь аль нэг тал руу нь орж, нөгөө талын эсрэг чиглэж байгаа хэрэг болно. Олон улсын харилцаа ээдрээтэй, дэлхийн том гүрнүүдийн эрх мэдэл, хүчний тэнцвэрт байдал алдагдсан, хүчний тэнцвэрийг сэргээн тогтоохын төлөөх өрсөлдөөн эрчимжсэн ийм нөхцөлд бага эдийн засагтай, хөгжиж байгаа орны хувьд Монгол Улс ШХАБ-д элсэх нь тусгаар тогтнолд эрсдэл дагуулах магадлалтай юм.

Гэхдээ ШХАБ-д элсэхээс шууд татгалзаж, хоёр хөршийнхөө дургуйцлыг төрүүлэхгүй байх нь бас нэг талаар чухал юм. Хэрэв ШХАБ-д элсэхгүй гэдгээ ил тод илэрхийлсэн нөхцөлд ОХУ, БНХАУ-ын зүгээс эдийн засаг, улс төрийн хориг саад явуулахгүй гэх газаргүй. Мөн бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийн үйл явцаас хоцрох, томоохон төслүүдийн гадна үлдэх эрсдэл байгаа юм. Ийм нөхцөлд Монгол Улс ШХАБ-д ажиглагч гишүүний байр сууриа аль болох удаан хугацаанд хадгалах нь зүйтэй. Гэхдээ Орос, Хятад хоёр ШХАБ-ыг цэргийн эвсэл болгон хөгжүүлэх зорилго ил тод болгож, хүрээллийг нь Баруун Өмнөд Ази, Ойрхи Дорнодын гээд олон өөр бүсийн улс орнуудаар тэлсэн нөхцөлд ШХАБ НАТО-гийн эсрэг эвсэл болон гарч ирэх боломж Евразийн бүс нутагт байна гэж харж байна.

ШХАБ-ын хүрэн дэх Монгол, ОХУ, БНХАУ-ын гурван талт хамтын ажиллагаа

Монгол Улс олон улсын харилцаа, дэлхийн бодлогод нөлөө бүхий 2 гүрний дунд оршиж, тэдэнтэй стратегийн түншийн түвшинд харилцаатай байгаа нь нэг талаар геополитикийн таатай нөхцөл юм. Аюулгүй байдлын хувьд дэлхий дахиныг хамарсан уламжлалт болон уламжлалт бус аюул занал, олон улсын терроризм, бүс нутгийн иргэний дайн, зөрчил, зэвсэгт бүлэглэлүүдийн харгис үйл ажиллагаа Монгол Улсын хилийг даван орж ирэх аюулыг хоёр хөрш маань хааж байна. Гэхдээ энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад орчин аюул занал, эрсдэлээс бүрэн хамгаалагдсан гэсэн үг биш, энэ гадаад орчны таатай нөхцөл урт настай байх эсэх нь Монгол Улсын төрийн зөв зүйтэй гадаад бодлого, олон талт хамтын ажиллагаанаас хамааралтай. Дэлхийн улс орнуудын харилцан хамаарал улам бүр гүнзгийрч, аюулгүй байдлын талаарх уламжлалт ойлголт өөрчлөгдөн, нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ, нээлттэй бус орчин бүрэлдэж байгаа нь Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд идэвхтэй бодлого барьж, олон талт дипломат ажиллагааг ашиглах шаардлага урган гарч байна. Гэхдээ бүрэлдэн тогтсон хуучин тогтолцоонд нэгдэн орохоос гадна, хоёр хөрш, бусад улс орон холбоодыг адилхан татан оролцуулсан аюулгүй байдал, яриа хэлэлцээний шинэ тогтолцоо бүрдүүлэхэд санаачилгатай ажиллах хэрэгтэй юм.¹⁰²

Өнгөрсөн түүхийн хугацаанд таатай харилцаатай байж ирээгүй Монгол, ОХУ, БНХАУ буюу хөрш 3 улс шинэ зууны эхэнд стратегийн түншлэл рүү тэмүүлж байгаа

¹⁰² ХИС-ОУХНСС, МУИС-ОУХНУС, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын гадаад дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ, хуудас 223, 2014 он.

нь олон улсын харилцаанд мөн л шинэлэг зүйл болов. ¹⁰³ Монгол Улс нь ОХУ-тай 2000 оноос гадаад худалдаа, эдийн засгийн хувьд эрчимтэй хамтарч ажилласан боловч Оростой хийх гадаад худалдааны эргэлт Хятадтай харьцуулахад бага байдаг. Монголын гол импортлогч түнш нь ОХУ. Оросоос нийт импортынхоо 22%-ийг авч байна. 2014 онд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд ОХУ Монгол Улстай одоогийн 1.6 тэрбум америк долларын худалдааны эргэлтээ 2020 он гэхэд 10 тэрбум америк долларт хүргэж нэмэгдүүлэх зорилт тавьсан юм. XXI зуун гарснаас хойш Монгол Улс хоёр хөршийнхөө нөлөөг тэнцвэржүүлэх зорилгоор “гуравдагч хөрш”-ийн бодлого зарласан боловч хоёр их хөршийн хамаарлыг төдийлөн холдуулж чадахгүй байна. Тухайлбал өнөөдөр Хятад улс дангаараа Монгол Улсын экспортын зах зээлийн 90%-ийг эзэлж байна. Монгол Улс нь 1949 онд БНХАУ -тай дипломат харилцаа тогтоосон ч Хятад нь 1961 онд НҮБ-ын гишүүн болох хүртэл Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөөгүй юм. 1990 оноос хойш л Монгол, Хятадын харилцаа эрчимтэй хөгжиж, өнөөдөр стратегийн иж бүрэн түншлэлд хүрээд байна. Өнөөдөр Хятад улс Монгол Улсын гадаад худалдааны хамгийн том түнш боллоо. 1990-ээд онд хоёр орны худалдааны эргэлт 33 сая америк доллар байсан бол өнөөдөр 3 тэрбум гаруй америк долларт хүрч, 100 дахин өссөн байна. Хятад нь Монголын гол экспортлогч орон бөгөөд нийт экспортын 89%-ийг Хятад дангаараа эзэлж байна. Харин нийт импортын 26%-г Хятадаас авч байна. XXI зуун гарснаас хойш Монгол Улс ОХУ болон БНХАУ-тай бүх талаар хамтын ажиллагааг хөгжүүлж, 3 талт стратегийн түншлэл рүү чиглүүлсэн. 3 улс стратегийн түншлэлийн үндсэн зарчмууд дээр тохиролцох шаардлага тулгарсан ч энэхүү шаардлагыг аажмаар тохиролцох нөхцөлийг бүрдүүлсэн нь Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн Монгол-Орос-Хятадын 3 талт уулзалт юм.¹⁰⁴ Монгол Улсын санаачилсан энэ механизм нь 3 талт дээд хэмжээний уулзалтыг Улаанбаатар хотноо жил бүр зохион байгуулах, ингэхдээ 3 улсын гадаад хэргийн сайд нар жил бүр Улаанбаатарт уулзаж, дээд хэмжээний уулзалтад бэлтгэх, дээд хэмжээний уулзалт нь олон нийтэд нээлттэй, 3 талт хамтын ажиллагааны үндсэн зарчмуудтай нийцсэн байх, дээд хэмжээний уулзалт 3 орны ашиг сонирхолд нийцсэн дамжин өнгөрөх тээвэр, дэд бүтэц, бүс нутгийн аюулгүй байдал зэрэг асуудлыг хэлэлцдэг байх гэсэн 3 зарчимтай. Монгол Улс нь 3 орны төмөр замын тээвэр, Орос, Хятадын байгалийн хийн хоолойг Монголын баруун бүсээр дамнан тавиулж, дамжин өнгөрөх тээврээс ашиг олон сонирхлоо давхар илэрхийлсэн.

ОХУ энэ уулзалтыг ШХАБ-ын жил тутмын дээд хэмжээний уулзалтын хүрээнд тогтмолжуулах сонирхолтой байна. Харин Хятад энэ уулзалтыг тогтсон давтамжгүйгээр хаана ч явуулах боломжтой гэсэн байр суурь илэрхийлсэн. Гэхдээ Хятадын дарга Монгол Улсын 3 талт механизмыг илүү томоор харж, Евразид төмөр зам тавих ОХУ-ын санаачилга, Монголын Галын зам төсөлтэй холбосон Хятад, Орос, Монголын хамтын оролцоотой 3 улсын эдийн засгийн корридор гаргах санал тавьсан юм. Хятадын эдийн засгийн 3 талт корридор байгуулах энэ зорилт

¹⁰³ Т.Төмөрхүлэг, Монголын асуудал Орос, Хятадтай учир холбогдсон нь, хуудас 12, 2014 он

¹⁰⁴ www.president.mn, president statement.

нь Хятадын Шинэ торгоны зам эдийн засгийн бүслүүр байгуулах санаачилгын гол тулгуурын нэг нь. “Хятад, Орос, Монголын дунд хамтын ажиллагааны маш том орон зай байна. 3 улсыг холбосон эдийн засгийн корридорыг Хятадын Торгоны зам эдийн засгийн бүс, Оросын тив дамнасан төмөр зам, Монголын талын зам хурдны автозамын төсөлтэй уялдуулж хэрэгжүүлэх нь аль аль талдаа ашигтай”¹⁰⁵ гэж Хятадын Гадаад хэргийн яамны мэдэгдэлд онцолсон байдаг. Хятадын Торгоны зам төслийг Евразийн эдийн засгийн холбоотой хамтарч хэрэгжүүлэхээр Орос, Хятад хоёр аль хэдийн тохироо хийсэн. Харин одоо Евразийн эдийн засгийн холбоог 3 талт эдийн засгийн корридортой уялдуулах асуудал яригдаж байна. Эндээс харахад Монгол, Орос, Хятад аль алиныхаа ашиг сонирхлыг харгалзан, Евразийн бүс нутагт хамтрах, хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Монгол Улсын хувьд хоёр хөрштэйгээ найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа улам бататгаж, цаашид гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэх нь нэн тэргүүний зорилт болдог. Хоёр хөрштэйгээ стратегийн болон стратегийн иж бүрэн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаанд хүрснийхээ хувьд цаашид Улаанбаатарын уулзалт 3 талт механизмын хүрээнд 3 орны эдийн засаг, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа, дамжин өнгөрөх тээвэр, төмөр зам, уул уурхайн бодлого гээд олон зүйлийг хэлэлцэн тохиролцох гарц нээгдэж байна. Өнөөдөр Монгол Улсад гадны цэрэг улс төрийн шууд дарамт байхгүй байгаа нь юу юунаас илүү чухал юм. Дэлхийн бодлогод гол нөлөө үзүүлэгч АНУ тэргүүтэй Өрнөдийн орнуудтай түншийн харилцааг хөгжүүлж, хоёр хөрштэйгээ стратегийн болон иж бүрэн стратегийн түншлэлд хүрлээ. Өөрөөр хэлбэл цэрэг, батлан хамгаалах салбарт илүү зардал гаргах шаардлага одоогийн улс төрийн гадаад орчин шаардахгүй байна. Гэхдээ Монгол Улсын энх тайван байдал цаашид урт удаан үргэлжлэх эсэх нь ОХУ, БНХАУ, АНУ-ын улс төрийн харилцаанаас ихээхэн хамаарах төлөвтэй байна. Төв Азид энэ 3 том гүрний байр суурь зонхилох нөлөөтэй байж, тэдгээрийн хоорондын харилцаанаас цаашид их зүйл хамаарах болов уу. Иймд гуравдагч хөршөө гэж үздэг АНУ, мөнхийн 2 хөрш ОХУ, БНХАУ-тай тогтоосон түншийн харилцаа болон тэдний зүгээс өөр хоорондоо баримтлах бодлого Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны анхаарах гол хүчин зүйлийн нэг юм.

¹⁰⁵ China proposes economic corridor with Russia and Mongolia, www.rt.com/business/246281-china-russia-mongolia-corridor/

ДҮГНЭЛТ

XX зууны сүүл үед ЗХУ задран унаснаар Евразийн их гүрний орон зай хоосорч, евразийн бус, дэлхийн их гүрэн АНУ дангаар ноёлох болсон. Гэхдээ энэ богино хугацаанд Еврази нь геополитикийн ач холбогдлоо хадгалж, Америк ч Евразийн их гүрэн эргэн сэргэхээс сэргийлж, дэлхийд оройлох үүргээ хэрэгжүүлж төдийлөн чадахгүй байна. Өнөөдөр Евразийн их гүрэн ОХУ эргэн сэргэх замдаа нэгэнт орж, түүний үүрэг нөлөө Төв Азид хүчтэй болж ирж байна. Орос нь геополитикийн тэргүүлэх чиглэл Еврази дахь нөлөөгөө алдахгүй байх, улам тэлэх, харин АНУ өөртэй нь сөргөлдөх их гүрнийг евразид гаргахгүй байх амин чухал ашиг сонирхлын төлөөх тэмцэл өрнөж байна.

Мөн бүс нутагтаа аль хэдийн оройлж, дэлхийн их гүрэн болох зорилго тавиад байгаа өмнөд хөрш БНХАУ-ын Төв Ази, цаашлаад Евразийн орон зайд нөлөөгөө бэхжүүлэх сонирхол улс төр, эдийн засгийн орчинд аль хэдийн байр сууриа эзэлжээ. Орос, Хятад гэсэн хоёр том гүрэн бүс нутагт эдийн засаг, улс төр, эрчим хүчний бодлогоо урагшлуулахын тулд бүс нутгийн хамтын ажиллагааны механизмуудын өргөн ашиглах, хөшүүрэг хийх нь улам эрчимжиж байна. Хоёр том гүрний амин чухал бүс болсон Төв Ази, түүний дотор ШХАБ-ын олон улсын харилцаанд эзлэх жин нөлөө улам өссөөр байна. ШХАБ-д Монгол Улс ажиглагчын байр сууриар хамтран ажиллаад 10 гаруй жил өнгөрлөө. Энэ хугацаанд Монгол Улс ШХАБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, өөрийн байр суурь санал санаачилгаа тодорхой хэмжээгээр илэрхийлж ирсэн. Гэхдээ 2014 оны Украины хямрал зэрэг олон улсын харилцааны асуудлууд, эдийн засаг, аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс өмнөд, хойд хоёр хөршийн ШХАБ-д өгөх ач холбогдол өсөж, энэ байгууллагын хүрээг тэлэх ялангуяа Монгол Улсыг гишүүнээр элсүүлэх сонирхол давамгайл болж ирж байна.

Хоёр хөршийн хамтдаа урагшлах, дэлхийн их гүрэн болох холыг харсан бодлого, тэмүүлэлд орчин үеийн олон улсын харилцааны тулгамдсан асуудал ялангуяа газрын тосны ханшийн уналт, Ойрхи Дорнодын хямралт байдал зэрэг нь эерэгээр нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл эдгээр сорилт бэрхшээлийг хоёр хөрш боломж, гарц болгон ашиглах зөв зүйтэй стратеги баримталж байна гэж дүгнэж байна. Нэг нь нөгөөгөө нөхөх стратеги одоогоор хоёр хөршийн улс төр, эдийн засгийн салбарт үйлчилж, энэ нь ч үр дүнгээ өгч байгаа өнөөдрийн энэ стратегийн ойр хамтын ажиллагаа юм. Энэ нөхцөлд хоёр их хөршийн дунд стратегийн чухал байршилд оршдог, хөгжиж байгаа орон Монгол Улсад хөгжлийнхөө хурдыг нэмэглүүлэх боломж, бас сорилтын аль аль нь тулгарч байна. Хоёр хөршийнхөө шахалт, шаардлагаар хамтын ажиллагааны механизмуудад нь оролцоод, ашиг хүртээд явах хязгаарлагдмал боломж байна. Нөгөө талаар хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харьцах үндсэн зарчмаа баримтлаад, аль болох шахалт шаардлагыг нь хүлээн авахгүйгээр, тухай бүрт нь дипломат ажиллагааны зөв зүйтэй аргыг ашиглаад явах. Энэ зуураа “Гуравдагч хөрш”-ийн бодлогоо баримталж, дундыг барьсан байр сууриар хоёр хөрш болоод гуравдагч хөрштэйгээ тэнцвэртэй харилцааг хөгжүүлэх нь зөв алхам гэж дүгнэж байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх ном

1. Аюулгүй байдлын судалгааны зарим асуудал, Д.Мягмар, 2014 он
2. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ, ХИС-ийн ОУХ, Нийгэм судлалын сургууль, МУИС-ийн ОУХНУС, Доктор, Профессор Д.Уламбаяр, 2014 он
3. Монголын асуудал Орос, Хятадтай учир холбогдох нь, Т.Төмөрхүлэг, 2014 он
4. Нартов Н.А. Геополитик, 2003 он
5. Төв Азийн Геополитик ба Монгол улс, Монгол улсын ШУА, Олон улс судлалын хүрээлэн, 2005 он.
6. Стратеги судлалын сэтгүүл 2003, 2004, 2006, 2014 он
7. Төв Азийн геополитикийн орчны хувьсал ба Монгол улсын аюулгүй байдал, МУ-ын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ, Удо Б.Баркманн, 197-213

Англи хэл дээрх цахим ном:

1. The Eurasia Idea by Alexander Dugin, paper, 1, November, 2009.
2. “Eurasia, the World Island: Geopolitics and Policymaking in the 21st Century”, Christopher J.Fettweis, Global Research, 2006
3. Expanding Eurasia: Russia’s European Ambitions, by Janusz Bugajski , page 1, August, 2008
4. Eurasian Integration-The View from Within, by Piotr Dutkiewicz and Richard Sakwa, page 262, 2015
5. The Grand Chessboard by Zbigniew Brzezinski, 1997
6. Is the Shanghai Cooperation Organization a Military Confederacy? Frederick Stakelbeck, Jr., 9/26/2005 .
7. Russia in the pursuit of Eurasian integration: developmental regionalism or identity project? by Kairat Moldashev and Mohamed Aslam, 2015.
8. Unequal Partners: China and Russia in Eurasiaby Anita Inder Singh, The Diplomat, June 03, 2015
9. Peter Brookes, “Club For Dictators: An ugly agenda for Asia”, The Heritage Foundation, June 12, 2006

Англи хэл дээрх нийтлэл:

1. China’s AIB and OBOR: Ambitions and Challenges, Zhinqun Zhu, October 09, 2015.
2. Does the Shanghai Cooperation Represent an Example of a Military Alliance? By T.Tugsbilguun (Mongolia) 2008-2009
3. Expanding Eurasia: Russia’s European Ambitions, by Janusz Bugajski , page 1, August, 2008
4. Eurasian Integration by Piotr Dutkiewicz and Richard Sakwa, page 262, 2015.
5. The Shanghai Cooperation Organization SIPRI Policy Paper No. 17, May 2007
6. Russia’s role in the SCO and Central Asia: Challenges and opportunities by Andrei Bystritsky Chairman of the board, Foundation for the Development and Support of the Valdai Discussion Club

7. Russia in the pursuit of Eurasian integration: developmental regionalism or identity project? by Kairat Moldashev and Mohamed Aslam, 2015.

Цахим хуудсууд:

1. <http://www.mfa.gov.mn>
2. <http://www.president.mn>
3. www.infomongolia.com/ct/ci/8351 www.rt.com/business/246281-china-russia-mongolia-corridor/
4. http://en.theorychina.org/xsqy_2477/201504/t20150407_321152.shtml
5. <http://www.britannica.com/place/heartland>
6. <http://tassgraphics.ru/item?id=33030>
7. <http://money.cnn.com/2015/11/12/news/economy/russia-economy-gdp-q3/>
8. http://www.asiaecon.org/special_articles/read_sp/12835
9. <http://www.alternet.org/world/how-russia-china-strategic-partnership-marks-new-global-power-shift>
10. <http://data.worldbank.org/indicator/MS.MIL.XPND.GD.ZS>
11. http://news.xinhuanet.com/english/2015-03/28/c_134105435.htm
12. <http://thediplomat.com/2015/03/confirmed-chinas-defense-budget-will-rise-10-1-in-2015/>
13. <http://thediplomat.com/2014/07/central-asias-energy-rush/>
14. <http://muse.jhu.edu/journals/wq/summary/v025/25.1cornell.html>
15. <https://www.rt.com/business/230567-china-urasian-economic-union/>